Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл			-
<b>Дүн</b>	<b>261,350.9</b>	<b>181,109.9</b>	<b>-80,241.0</b>

*Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 81.6 хувь буюу 147,797.9 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн сангийн авлага, 9.1 хувь буюу 16,500.0 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага, 9.3 хувь буюу 16,812.0 мянган төгрөг нь ЗДТГ-ын авлага байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	17,790.4	16,812.0	-978.4	9.3
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	10.1		-10.1	

**Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

СХСан	203,195.4	147,797.9	-55,397.5	81.6
ОНХСан	40,355.0	16,500.0	-23,855.0	9.1
<b>НИЙТ ДҮН</b>	<b>261,350.9</b>	<b>181,109.9</b>	<b>-80,241.0</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 317,251.1 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 289,005.5 мянган төгрөг болж, 28,245.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Дуусаагүй үйлдвэрлэл	100,570.4	100,570.4	-
Тусгай зориулалттай материал	98,128.0	120,847.3	22,719.3
Бичиг хэргийн материал	1,546.0	1,483.5	-62.5
Сэлбэг хэрэгсэл	10,200.0	-	-10,200.0
Түлш шатах тослох материал		2,030.0	2,030.0
Барилга засварын материал	3,000.0	3,000.0	-
Бусад хангамжийн материал	26,686.7	31,991.8	5,305.1
Мал амьтад	27,120.0	27,120.0	-
Нөөцийн бараа	50,000.0	1,962.5	-48,037.5
<b>Дүн</b>	<b>317,251.1</b>	<b>289,005.5</b>	<b>-28,245.6</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 289,005.5 мянган төгрөг болж өмнөх оноос 28,245.6 мянган төгрөгөөр буурсан нь Орон нутгийн хөгжлийн санд бүртгэлтэй байсан дуусаагүй барилга байгууламж ашиглалтад орсонтой холбоотой данснаас хасаж үндсэн хөрөнгөнд бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	2,806.0	806.0	- 2,000.0	0.3
ЗДТГ	163,874.7	184,846.6	20,971.9	64
Сургууль		600.0	600.0	0,2
Соёл		220.0	220.0	0,1
ОНХС	150,570.4	102,532.9	-48,037.5	35.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>317,251.1</b>	<b>289,005.5</b>	<b>-28,245.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 206,849.6 мянган төгрөгийн бараа материалаас 151,642.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 18,208.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хандиваар, 36,998.0 мянган төгрөгийн бараа материалыг бусдаар авсан байна. Мөн нийт хасагдсан 235,095.1 мянган төгрөгийн бараа материалаас 235,095.1 мянган төгрөгийг байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	206,849.6	Хасагдсан	235,095.1
Худалдан авсан	151,642.8	Худалдсан, зарцуулсан	235,095.1
Хандив	18,208.8	шилжүүлсэн	-
бусад	36,998.0	бусад	-

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,129,111.0 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 3,729,390.5 мянган төгрөг болж 600,279.5 мянган төгрөгөөр өссөн байна.

**Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	3,093,204.0	3,693,483.5	600,279.5	99.0
Барилга байгууламж, орон сууц	1,959,643.8	2,274,919.9	315,276.1	61.0
Тээврийн хэрэгсэл	285,194.2	310,602.6	25,408.4	8.3
Машин тоног төхөөрөмж	159,991.1	201,671.7	41,680.6	5.4
Тавилга эд хогшил	50,997.7	67,037.9	16,040.2	1.8
Зам гүүрийн байгууламж			0.0	0.0
Дуусаагүй барилга байгууламж		58,490.9	58,490.9	1.6
Номын фонд	1,761.3	1,761.3	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	635,615.9	778,999.2	143,383.3	20.9
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	35,907.0	35,907.0	0.0	1.0
Программ хангамж	475.0	475.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	35,432.0	35,432.0	0.0	1.0
<b>НИЙТ ДҮН</b>	3,129,111.0	3,729,390.5	600,279.5	100.0

*Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 126,007.6 мянга, аймаг сумын ОНХС -аас 440,074.1 мянга, Шинэ хөдөө төсөл хөтөлбөрөөс 149,150.0 мянга, аймгийн ЗДТГ -аас 20,340.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, аймгийн ИТХ -ын 2024 оны 11 дүгээр сарын 22 -ны өдрийн 2/13 дугаар тогтоолоор 111,679.6 мянга, аймгийн Засаг даргын 2023 оны А/147 дугаар захирамжаар 19,990.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан. ИТХ нь төсвийн хөрөнгөөр 1,000.0 мянга, 3,377.0 мянган төгрөгийн суурин компьютерыг аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 99 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар үнэ төлбөргүйгээр орлогод авсан байна. Сумын ИТХ -ын өмчлөлд байсан фургон авто машиныг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэн өгч аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/147 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар дуудлага худалдаанд оруулж 5,000.0 мянган төгрөгөөр данснаас хассан байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	151,094.1	150,471.1	-623.0	4
ЗДТГ	2,978,016.9	3,578,919.4	600,902.5	96
Соёл			0.0	0
ЕБС			0.0	0
Цэцэрлэг			0.0	0
Эмнэлэг			0.0	0
ОНХСан			0.0	0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>3,129,111.0</b>	<b>3,729,390.5</b>	<b>600,279.5</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 600,279.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 82.8 хувь буюу 612,941.5 мянган төгрөгийг хөрөнгийн үнэ төлбөргүй шилжүүлэн, бусдаар авсан нь голлох нөлөө үзүүлж байна .

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	<b>739,949.1</b>	Хасагдсан	<b>139,669.60</b>
Худалдан авсан	127,007.6	Худалдсан	

**Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хандиваар		Акталсан	136,669.60
Шилжүүлэн авсан	169,490.4	Шилжүүлсэн	3000
бусад	443,451.1	Бусад	

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,115.0 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 12,484.0 мянган төгрөг болж 9,369.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	3,115.0	12,484.0	9,369.0	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг		820.0	820.0	6.6
Татаас санхүүжилт шилжүүлгийн өглөг			-	-
Байгууллагад төлөх өглөг	3,115.0	11,664.0	8,549.0	93.4
Хувь хүмүүст өгөх өглөг			-	-
<b>Дүн</b>	<b>3,115.0</b>	<b>12,484.0</b>	<b>9,369.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 12,484.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд энэ нь сумын ЗДТГ, ИТХ -ын ажилчдаас илүү суутгасан НДШ 820.0 мянган төгрөг, Сургуулийн халаалт 7,927.3 мянган төгрөг, Цэцэрлэгийн гэрэл цахилгаан 621.6 мянган төгрөг, аймгийн Ойн ангид өвсний үнэ 3,115.0 мянган төгрөгийн өрийн үлдэгдэл байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ		249.8	249.8	2.0
ЗДТГ	3,115.0	3,685.2	570.2	29.5
ЕБС		7,927.3	7,927.3	63.5
Цэцэрлэг		621.7	621.7	5.0
<b>ДҮН</b>	<b>3,115.0</b>	<b>12,484.0</b>	<b>9,369.0</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,359,709.3 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 3,809,402.4 мянган төгрөг болж, 449,693.2 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	511,503.9	511,503.9	-	13.4
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	511,503.9	511,503.9	-	13.4
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,714,043.5</b>	<b>3,163,736.7</b>	<b>449,693.2</b>	<b>83.1</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	134,161.9	134,161.9	-	3.5
<b>Дүн</b>	<b>3,359,709.3</b>	<b>3,809,402.5</b>	<b>449,693.2</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 449,693.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.7 Орлогын данс**

Сумын ИТХ-ын 2023.12.19-ний өдрийн хуралдаанаар 17/06 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 544,533.4 мянга, хүү торгуулийн орлогыг 5,000.0 мянга, нийт 549,533.4 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024.09.25-ний өдрийн 27 дугаар тогтоолоор 64,697.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

<b>Орлогын төрөл</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>Зөрүү</b>	<b>Хувь</b>
1.Татварын орлого	677,633.4	848,731.9	171,098.5	125.2
ЦХТА рлого /суутган/	280,000.0	327,652.6	47,652.6	117.0
ҮХЭД хөрөнгийн албан татвар	2,400.0	2,030.0	(370.0)	84.6
Бууны татвар	6,480.0	7,080.0	600.0	109.3
ИОТХ	121,700.0	169,052.1	47,352.1	138.9
Улсын тэмдэгтийн хураамж	13,000.0	36,117.2	23,117.2	277.8
Хадгаламжийн хүүгийн орлого	59,040.0	67,860.7	8,820.7	114.9
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого	3,500.0	330.0	(3,170.0)	9.4
Малд ногдуулах албан татвар	78,748.4	54,481.2	(24,267.2)	69.2
Газрын төлбөр	2,000.0	1,738.5	(261.5)	86.9
Газрын дуудлага худалдаа	1,200.0	1,398.2	198.2	116.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	19,408.0	20,729.1	1,321.1	106.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	66,368.0	141,730.1	75,362.1	213.6
ТТАМАТөлбөр	1,000.0	218.7	(781.3)	21.9
Ус рашааны төлбөр	20,000.0	18,313.5	(1,686.5)	91.6
Газрын тос орлого	2,789.0		(2,789.0)	-
2.Татварын бус орлого	6,000.0	7,687.6	1,687.6	128.1
2.1.Хүү торгуулийн орлого	5,000.0	6,249.5	1,249.5	125.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.0	1,438.1	438.1	143.8
<b>Нийт дүн</b>	<b>684,633.4</b>	<b>856,419.5</b>	<b>172,786.1</b>	<b>125.1</b>

*Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 125.1 хувь буюу 172,786.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 47,652.6 бууны албан татвар 600.0 мянга, иргэний орлого тодорхойлох хуудсаар ногдуулсан албан татвар 47,352.1 мянга, улсын тэмдэгтийн хураамж 23,117.2 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 8,820.7 мянга, газрын дуудлага худалдаа 198.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1,321.1 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөр 75,362.1 мянга, хүү торгуулийн орлого 1,249.5 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.



Харин иргэний үл хөдлөх хөрөнгийн албан татвар 370,0 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 3,170.0 мянга, малын хөлийн албан татвар 24,267.2 мянга, газрын төлбөр 261.5 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 781.3 мянга, ус рашаан ашигласны төлбөр 1,686.5 мянга, газрын тосны орлого 2,789.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1,438.1.0 мянган төгрөгийн орлого оруулж үүргээ биелүүлээгүй байна

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 89,599.2 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 55,397.5 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### **3.8 Зардлын данс**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2563,713.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,239,583.7 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,509,104.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 730,478.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

*Хүснэгт №14. Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>1</b>	<b>Баянцагаан сумын Засаг дарга</b>	<b>2,563,713.5</b>	<b>2,239,583.7</b>	<b>324,129.8</b>	<b>87.4</b>
2	70105-80101 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	173,447.9	161,440.7	12,007.2	93.0
3	70105-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	500.0	500.0	0	100.0
4	70106-80101 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	645,466.3	599,867.2	45,599.1	92.9
5	70106-80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	164,019.9	155,993.9	8,026.0	95.1
6	70106-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,000.0	1,000.0	0	100.0
7	70106-81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	108,000.0	101,625.8	6,374.2	94.1
8	70106-81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	151,267.3	136,131.1	15,136.2	89.9
9	70106-82212 хур хог хаягдал, орчны бохирдол	39,408.0	39,395.1	12.9	99.9
10	71602-80111 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	91,717.2	91,133.5	583.7	99.4
11	71702 -80111 Соёл урлаг	43,925.1	42,685.6	1,239.5	97.2
12	71801 -80111 Сургуулийн өмнөх боловсрол	25,156.3	24,978.9	177.4	99.3
13	71802-80111 Ерөнхий боловсрол	153,753.6	153,753.1	0.5	100.0
14	70503-80904 Орон нутгийн зорилтот орон оруулалт	94,000.0	71,687.0	22,313.0	76.3
15	70503-83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох	541,032.3	540,994.9	37.4	100.0
16	70503-83403 ОНХС-ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	101,672.0	59,240.5	42,431.5	58.3
17	70503-83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар	78,748.4	58,556.4	20,192.0	74.4
18	72101-82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	150,599.2	600.0	149,999.2	0.4
	<b>Нийт дүн</b>	<b>2,563,713.5</b>	<b>2,239,583.7</b>	<b>324,129.8</b>	<b>87.4</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### **3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдаанаар 17/06 дугаар тогтоолоор нийт 2,499,034.5 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024.09.25-ний өдрийн 27 дугаар тогтоолоор 64,679.0 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	178,204.0	165,600.2	173,947.9	4,256.1
Засаг даргын Тамгын газар	1,114,326.5	1,009,861.6	1,109,161.5	5,165.0
Сургууль	216,935.6	222,709.0	153,753.6	63,182.0
Цэцэрлэг	26,156.3	25,156.3	25,156.3	1,000.0
Эрүүл мэндийн төв	91,717.0	91,717.2	91,717.2	-0.2
Соёлын төв	39,600.0	43,925.1	43,925.1	-4,325.1
Сум хөгжүүлэх сан		150,599.2	150,599.2	-150,599.2
Орон нутгийн хөгжлийн сан		789,465.9	815,452.7	-815,452.7
<b>Нийт дүн</b>	<b>1,606,939.4</b>	<b>2,499,034.5</b>	<b>2,563,713.5</b>	<b>896,774.1</b>

Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023.12.19-ний өдрийн хуралдаанаар 17/06 дугаар тогтоолоор анх 2,499,034.5 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024.09.25-ний өдрийн 27 дугаар тогтоолоор 64,679.0 мянган төгрөгөөр өсгөж 2,563,713.5 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 642,704.3 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 732,493.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 682,633.4 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 89,599.2 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос, 415,283.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас 732,493.3 мянга, орон нутгийн орлогын санхүүжилтээс 854,981.5 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 606,514.5 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,438.1 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжих санхүүжилт нийт 2,563,713.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 84,594.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН
ЗДТГ	1,109,161.5	1,034,013.1	75,148.4	93.2	75,148.4
ИТХ	173,947.9	161,940.7	12,007.2	93.1	12,007.2
Соёлын төв	43,925.1	42,685.6	1,239.5	97.2	1,239.5
Сум хөгжүүлэх сан	150,599.2	600.0	149,999.2	0.4	
Сургууль	153,753.6	153,753.1	0.5	100.0	0.5
Цэцэрлэг	25,156.3	24,978.9	177.4	99.3	177.4
ЭМТ	91,717.2	91,133.5	583.7	99.4	583.7

**Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

ОНХС	815,452.7	730,478.8	84,973.9	89.6	
<b>Нийт дүн</b>	<b>2,563,713.5</b>	<b>2,239,583.7</b>	<b>324,129.8</b>	<b>87.4</b>	<b>89,156.7</b>

*Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,239,583.7 мянган төгрөг буюу 87.4 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 75,148.4 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 12,007.2 мянга, Соёлын төвийн урсгал зардлыг 1,239.5 мянга, Цэцэрлэгийн урсгал зардлыг 177.4 мянга, Эрүүл мэндийн төвийн урсгал зардлыг 583.7 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 84,973.9 мянга, сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой 149,999.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.9.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас ЗДТГ-т хуваарилсан 21,559.4 мянга, аймгийн ИТХ -аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 1,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 3,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 3,273.1 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 16,286.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж дансны үлдэгдэлгүй байна.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

<b>Үзүүлэлт</b>	<b>ИТХ</b>	<b>ЗДТГ</b>	<b>НИЙТ</b>
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,000.0	21,559.4	22,559.4
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0	21,559.4	22,559.4
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	1,000.0	21,559.4	22,559.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000.0	2,000.0	3,000.0
Бараа үйлчилгээний бусад зардал		3,273.1	3,273.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж		16,286.3	16,286.3
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>

*Эх сурвалж: Баянцагаан сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дүгээр сарын 07-ний өдрийн 1/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Баянцагаан сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Н.Гансүх, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Д.Аюуш нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 65 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2,476,326.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,476.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 16,096.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 2024 онд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 128 мэдээллийг хугацаанд нь 15 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл мэдээлэх хугацаа болоогүй байна.

#### 4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баянцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

#### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 алдаа зөрчил илэрснээс зөрчлийг арилгах албан шаардлага, төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа хэрэгжилтийг сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1/92 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	0	1	0			100
Нийт	1	0	1	0			100

#### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

#### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 108,000.0 төгрөгөөр баталж 101,625.8 мянган төгрөгийг зарцуулж 6,374.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 62 хувийг

журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд өвс тэжээл, 38 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд тус тус зарцуулжээ.

#### 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 94 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,563,713.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,239,583.7 мянган төгрөгийг зарцуулж 87.3 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 16 нэр төрлийн орлогоор 683,633.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 856,419.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлогыг 125.3 хувь буюу 172,786.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 47,652.6 мянга, үйл ажиллагааны орлого 47,352.1 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 8,820.7 мянга, ан агнуурын орлого 75,362.1 мянган төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой бөгөөд 5 төрлийн 28,850.0 мянган төгрөгийн орлого тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Баянцагаан сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Өөрчлөлтгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЗДТГ	1	1	1			1			
ИТХурал	1	1		1					
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>3</b>		<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 121,121.7 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 14,886.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 106,234.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн



**Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
	Тоо	Дүн	Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн зөрчил</b>										
<b>ЗДТГ</b>	3	6,019.8			1	1,628.6	2	4,391.2		
<b>ИТХ</b>	2	3,594.8			1	184.0	1	3,410.8		
<b>ОНХСан</b>										
<b>СХС</b>	1	13,074.3			1	13,074.3				
<b>СТА зөрчлийн дүн</b>	6	22,688.9			3	14,886.9	3	7,802.0		
<b>СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
<b>ЗДТГ</b>	1	98,432.8					1	98,432.8		
<b>ОНХСан</b>										
<b>ИТХурал</b>										
<b>Нийцлийн аудитын дүн</b>										
<b>Нийт дүн</b>	1	98,432.8					1	98,432.8		

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 22,688.9 мянган төгрөгийн 7 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 98,432.8 мянган төгрөгийн 7 зөрчил тус тус илэрсэн байна.

Хүснэгт 19. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
<b>Засаг даргын Тамгын газар</b>					
		104,452.6			
1	Тус байгууллагын 2 албан хаагчид 16,286.3 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олгосон ба ХХОАТ -ыг суутгаагүй байна.	1,628.6	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Чинбат Н.Амартүвшин
2	Гэрэл цахилгааны зардлаас 2024 оны 12 сарын 26 - ны өдөр "Далай банди" ХХК руу 1,540.0 мянган төгрөгийг шилжүүлж гэрлийн утас авсан байна.	1,540.0	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Чинбат Н.Амартүвшин
3	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас идэвхтэн байгаль хамгаалагч 3 иргэний урамшууллаас 2,851.2 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэл авч мөнгийг шилжүүлсэн боловч Нийгмийн даатгалд мэдээлээгүй байна.	2,851.2	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Чинбат Н.Амартүвшин
4	Тайлант онд шилэн дансны цахим хууласт цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 70,848.8 мянган төгрөгийн 2 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагаын 27,584.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, халаалт, бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээнүүдийг бахршуулаагүй байна.	98,432.8	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Чинбат Н.Амартүвшин
<b>Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</b>					
		3,594.8			
1	Тайлант онд шуудан холбооны зардлаас сумын ИТХ-ын 4 албан хаагчид 184.0 мянган төгрөгийн нэгж авч өгсөн байна.	184.0	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Болормаа Н.Амартүвшин
2	Бараа үйлчилгээний бусад зардлаас 3,410.8 мянган төгрөгийг уралдаан тэмцээний зардалд зарцуулсан байна.	3,410.8	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Э.Болормаа Н.Амартүвшин
<b>Сум хөгжүүлэх сан</b>					
		13,074.3			
1	Хоршоо хөгжүүлэх сангаас 2013-2021 онд олгосон 3 иргэний нийт 13,074.3 мянган төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэй, барагдаагүй байна. Энэ нь Иргэний хуулийн 453.1 "Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт	13,074.3	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга Нягтлан бодогч	Н.Гансүх Д.Аюуш Т.Одмаа

**Баянцагаан сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	тавих журам” -ийн 6 дугаар зүйлийн 6.9 Хуулийн этгээд иргэн нь авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн даснад буцаан төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.				
Орон нутгийн хөгжлийн сан		-			
1					
	Нийт дүн		121,121.7		

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 24,267.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 24,267.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгөв.

**5.1 Албан шаардлага**

5.1.1 Тайлант онд малын тоо толгойн албан татварын орлогыг 78,748.4 мянган төгрөгөөр төлөвлөж ногдуулалт хийсэн байхад 54,481.2 мянган төгрөг төвлөрүүлж 24,267.2 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Энэ нь мал тоо, толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Малын тоо толгойн албан татварын 24,267.2 мянган төгрөгийн дутуу төвлөрсөн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**


(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд малын тоо толгойн албан татварын орлогыг 78,748.4 мянган төгрөгөөр төлөвлөж ногдуулалт хийсэн байхад 54,481.2 мянган төгрөг төвлөрүүлж 24,267.2 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.	1	24,267.2			1	24,267.2				
Дүн	1	24,267.2			1	24,267.2				



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								

-----oOo-----

